



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/260

Чингис хот

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Намсрайн Хүрэлээ Цэргийн гавьяаны одонгоор, Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд бөгөөд штабын дарга Нямбуугийн Ганболд бригадын генерал цолоор тус тус шагнагдсан тул хүндэтгэл үзүүлэхэд 640,000 (зургаан зуун дөчин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011601

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 28 өдрийн А/260
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Мөнгөн аяга	ш	2	580.000
2	ааруул, хадаг	ш	2	60000
Нийт үнэ				640.000